

# **ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН СОЛОНГОС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН**

## **“IUU СОЛОНГОС СУДЛАЛ” эрдэм шинжилгээний сэтгүүлийн өөрийн шаардлага**

### **Сэдвийн шаардлага**

1. Солонгос судлал(түүх, угсаатны зүй, орон судлал, улс төр, эдийн засаг, нийгэм, хэл, соёл, утга зохиол, боловсрол, шашин гэх мэт салбар ухаан багтана)-ын тодорхой асуудлыг хөндсөн судалгааны үр дүнг тусгасан байх
2. Онол аргазүйн түвшин, шаардлагыг хангасан байх, шинэ санал, дүгнэлт дэвшүүлэх
3. Урьд өмнө нийтлэгдээгүй байх
4. Өгүүллийг монгол, солонгос хэлний аль нэгээр бичих

### **Техник шаардлага**

1. Өгүүллийн эхний нүүрний баруун дээд өнцөгт зохиогчийн нэр, харьяа байгууллага, албан тушаал, эрдмийн зэрэг, цол, цахим хаяг байна. Багаар гүйцэтгэсэн бол зохиогчийн нэрсийг 1., 2. гэх мэтээр тэмдэглэн нэрсийн доор зохиогчийн харьяа байгууллага, албан тушаал, эрдмийн зэрэг, цол, цахим хаяг бичсэн байна.
2. Өгүүлэлд өгүүллийн нэр(монгол, англи, солонгос хэл дээр), зохиогчийн мэдээлэл, түлхүүр үг(5-аас доошгүй), удиртгал, судалгааны үндсэн хэсэг, үр дүн эсвэл дүгнэлт, ном зүй гэсэн хэсэгтэй байна.
3. Товч агуулга(Abstract) нь агуулгыг товчилсон 10-аас доошгүй мөр, 40-өөс доошгүй үгэнд багтаан солонгос, англи хэлний аль нэгээр бичнэ.
4. Бичвэрийг Microsoft Office Word(**хэвлэлийн үед алдаа гардаг учир ханком оффис программ ашиглахгүй байх**) программ ашиглан бичих ба хэмжээ нь А4(дээд, доод, баруун, зүүн 2 см) хэмжээтэй 8-12 нүүр байна.
5. Монгол хэлээр бичих бол Times New Roman, солонгос хэлээр бол Batang(바탕) фонтыг ашиглах ба өгүүллийн нэр 15, зохиогчийн мэдээлэл 13, гарчиг 14, дэд гарчиг 12, үндсэн бичвэр 11, хураангуй 10, эшлэл, зүүлт, зураг(хүснэгт, график, диаграмм)-ийн тайлбар 9, ном зүй 10, мөр хоорондын зайд single буюу 1.0 байна.
6. Ном зүйд орсон бүтээлийг монгол, солонгос, англи бусад гадаад хэл, цахим эх сурвалж дарааллаар жагсаана. Эшлэл аваагүй зохиогчийн нэрийг ном зүйд оруулахгүй.
7. Эшлэлийг тайлбар зүүлт(Footnote)-ээр оруулах ба монгол, солонгос, англи эсвэл бусад хэл дээр гэсэн дарааллаар байна.
8. Ном зүй, эшлэл зүүлтийг APA(АНУ-ын Сэтгэл зүйн нийгэмлэг) бичвэрийн стандартыг дагана.

국제울란바타르대학교 한국학 연구소  
"IUU 한국학" 학술지 원고 작성 요령

## 주제

1. 한국학(언어, 교육, 역사, 지역, 정치, 경제, 사회, 문화, 문학, 민속학, 종교학 등)과 관련된 전 학문 계열의 관련 주제
2. 전문성과 독창성 있는 주제와 이론적 분석을 갖춘 학술 논문이어야 한다.
3. 이전에 저서 및 기타 학술지 등에 게재되지 않았거나 게재될 예정이 없는 논문이어야 한다.
4. 원고는 한국어 또는 몽골어로 작성한다.

## 원고 작성 요령

1. 원고 첫 페이지 오른쪽 정렬에 저자의 성명, 소속기관명, 직위, 최종학위, 연락처를 기재한다. 공동연구일 경우 1., 2. 등으로 분류하여 그 순서대로 성명, 소속기관명, 직위, 최종학위, 연락처를 기재하도록 한다.
2. 원고의 표지에는 논문 제목(몽골어, 한국어, 영어) 및 저자 정보, 주제어(5 개 이하), 서론, 본론, 결론 또는 분석 결과, 참고문헌, 요약(한국어, 영어 중 선택) 이 포함된다.
3. 논문요약(Abstract)에는 10 줄 이하, 40 단어 이하를 포함한 논문 내용을 한국어 또는 영문으로 작성한다.
4. 원고는 MS 오피스(**출판 오류로 인해 한컴 오피스 작성 불가**)를 활용하여 A4 용지(위, 아래, 왼쪽, 오른쪽 모두 2 cm) 분량으로 8-12 쪽 내외로 한다.
5. 논문을 작성할 때에 몽골어는 Times New Roman, 한국어는 Batang(바탕) 글꼴을 사용하며, 각 부분별 속성은 아래와 같이 한다. 줄간격은 single로 한다.

◦논문제목: 바탕 15, 진하게, 가운데 정렬  
◦저자 정보: 바탕 13, 진하게, 오른쪽 정렬  
◦큰 제목: 바탕 14, 진하게, 가운데 정렬  
◦중간/작은 제목: 바탕 12, 진하게, 들여쓰기 10  
◦본문: 바탕 11, 들여쓰기 10, 양쪽 혼합정렬  
◦각주내용: 바탕 9, 양쪽 혼합 정렬  
◦논문요약: 바탕 10, 들여쓰기 10, 양쪽 혼합 정렬  
◦참고문헌: 바탕 10, 왼쪽 여백 10, 양쪽 혼합 정렬

6. 참고문헌은 몽골어, 한국어, 영어 또는 기타 언어, 전자 자료 순으로 하여, 알파벳 또는 가나다의 순서에 따라 배열한다. 본문에서 언급된 논문, 저서만 제시한다.
7. 인용문의 경우, 본문에서 내용주로 처리하고, 내용의 설명은 각주로 제시하며, 몽골어, 한국어, 영어 또는 기타 언어 순으로 다음과 같은 예시로 배열한다.
8. 본문 내 인용, 참고문헌 목록은 APA 양식을 따른다.